



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2009 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/388

Мандалговь

“Бизнес эрхлэгчдийг дэмжих төвийн
их засвар” ажлыг шалгах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.5, 57.1.21, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Бизнес эрхлэгчдийг дэмжих төвийн их засвар” ажлын нэмэлт хийгдэж буй ажлыг газар дээр нь шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Чагнаадорж	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
Гишүүд:	Ц.Лхагвасүрэн	(Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга)
	Ж.Уянга	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Эдийн засаг, төлөвлөлтийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн)
	Э.Энхмэнд	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
	Э.Цэрэннадмид	(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилга, авто замын хяналтын улсын байцаагч)
	С.Энхбат	(БЗӨБ ЦТС ТӨХК-ийн Дундговь цахилгаан түгээх сүлжээ салбарын ерөнхий инженер)
	Ч.Лхагваа	(“Төсөв төсөл” ХХК-ийн архитектор)

2. “Бизнес эрхлэгчдийг дэмжих төвийн их засвар” ажлын нэмэлт хийгдэж буй ажлыг газар дээр нь шалган барилгын норм дүрэм, стандартын дагуу хийгдэж буй эсэх, төсвийг дахин нягталж дүгнэлт гарган тооцооллыг танилцуулахыг ажлын хэсэг (Э.Чагнаадорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ 4822111247